

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ ХШҮХ-ЭЭС ӨГСӨН
ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022 оны 11 дүгээр сарын 21

Сайнцагаан сум

№	Хөтөлбөр (хөтөлбөрийн нэр), хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээ (гарц)-ний шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
1	“Дундговιο ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны ургалтын чанарт анхаарч байнгын усалгаа арчилгаа хийх	Хуваарийн дагуу услах, бордох, ургаагүй суулгацыг зольж тарьсан эсэх /тийм үгүй/	Тийм	Байгууллагын хуваарьт газар тарсан модны ургаагүй 28 ш модыг шинэчлэн сольж батлагдсан хуваарийн дагуу долоо хоногийн 1 дэх 4 дэх өдрүүдэд тогтмол усалж байна.	100
2	Байгууллагын гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Модны ургалтын хувь	70	Төлөвлөгөөний дагуу Байгууллагын хашаанд 150 ширхэг мандлын цэцэг 2кг зүлгийн үр, 5ш ургаагүй суулгацын шинэчлэн суулгаад байна. Цэнгэлдэх хүрээлэнгийн ойр орчимд спорт холбоодтой хамтран зураг төсвийн дагуу 6000 ширхэг модыг суулгаж усалгаа арчилгааг хийж байна ургалт 80 хувьтай байна.	100
3	80 жилийн ойг угтаж байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	Төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Дээврийн засварын ажлыг тендерт “Мандал өргөө голомт” ХХКомпани шалгарч гэрээний дагуу ажлыг 2022 оны 04 дүгээр сард 100 хувь гүйцэтгээд байна. Байгууллагын хаягийг шинэчлэн гэрэлтүүлэгтэй кирилл болон хуучин монгол бичгээр бичиглэн хос бичигтэй самбараар сольсон. Мөн ногоон байгууламж дахь сүүдрэвч, цэнгэлдэх хүрээлэнгийн А/блок хэсгийг сэргээн засварлаад байна.Тус ажлын хэрэгжилт 100 хувьтай биелээд байна.	100

4	Захиргааны ерөнхий хуулийн дагуу захирамжлалын баримт бичигт хяналтын дагалдах бий болгож үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	Хяналтын дагалдах хуудас хөтөлсөн албан бичгийн хувь	100	Байгууллагын даргын 2022 оны А/52 тоот тушаалаар хяналтын дагалдах хуудасны маягыг баталж захирамжлалын баримт бичигт хяналтын дагалдах хуудсыг 100 хувь хөтлөн ажиллаж байна.	100
5	Эрх зүйн актаа хуваарийн дагуу хянуулж байх	Эрх зүйн акт хянуулсан тоо	2	Хууль зүйн хэлтэст хуваарийн дагуу 04 дүгээр сарын 13, 10 дугаар сарын 30 ны өдөр нийт 123 эрх зүйн актыг 2 удаа хянуулж тус хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
6	Монгол Улсын баримт бичгийн стандарт болон Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	13	2020 оны 246 дугаар тогтоолын дагуу албан хаагчдад, архив бичиг хэргийн ажилтнаар сургалт бэлтгэн явуулж тухай бүр арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.Сургалтад нийт 15 албан хаагч хамрагдаад байна.	100
7	Албан хаагчдын баримт бичгийн стандарт анхаарч ажиллах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	10	Баримт бичгийн стандарт сэдэвт сургалт явуулж, гүйцэтгэх 10 албан хаагчаас гарсан баримт бичигт хяналт тавьж тухай бүр арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	100
8	Хэвлэмэл хуудасны нэр төрлийн индексийг байгууллагын даргын албан тушаалаар батлуулах	Жагсаалтыг газрын даргаар батлуулсан эсэх /тийм үгүй/	Тийм	Байгууллагын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар хэвлэмэл хуудасны индексийг батлуулан хэвлэмэл хуудсыг дугаарлан үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100
9	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө арга хэмжээ тус бүрээр тайлагнах	Арга хэмжээний тоо	46	Төлөвлөгөөний 46 заалт бүхий арга хэмжээг, арга хэмжээ тус бүрээр тайлагнан ажиллаж байна.	100
10	Төлөвлөлт, тайлагналтын чанарт анхаарч, албан хаагчдыг чадавхжуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	2	Засгийн газрын хэрэг эрхлэх газраас батлан гаргасан 217,218 дугаар тогтоолын дагуу ХШҮхэлтсээс явуулсан хоёр удаагийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж чадавхжуулаад байна.	100

11	Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, төлөвлөгөө боловсруулан ажиллаж, тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	Байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж газрын даргын тушаалаар батлуулан ажиллаж байна. Мөн 16 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна.	100
12	Хувийн хэргийг журамд заасны дагуу бүрэн бүрдүүлж байх	Баяжуулсан хувийн хэргийн тоо	15	Байгууллагын 15 албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу тухай бүр баяжуулан ажиллаж байна. Баяжуулсан хувийн хэргийн тоо 15	100
13	Хариутай бичгийг хяналтад авч хугацаанд шийдвэрлэх	Шийдвэрлэсэн албан бичгийн хувь	100	БТСГазарт 2022 оны 01 дүгээр сараас одоог хүртэл нийт 73 хариутай бичиг ирснийг бүртгэл хяналтад авч 100 хувь албан бичгийн хариуг холбогдох аж ахуйн нэгж байгууллагат хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	100
14	ERP системийн нэвтрүүлж бүх албан хаагч ашиглаж сурах	Шаталсан сургалт хамрагдсан албан хаагчдын тоо	10	ЗДТГ-аас зохион байгуулсан цахим болон танхимаар зохион байгуулсан ERP системийг хэрхэн ашиглах сэдэвт сургалтад удирдах, гүйцэтгэх 10 албан хаагчдыг бүрэн хамруулсан. БТСГ-ын удирдах болон гүйцэтгэх албан хаагчид өдөр тутам үйл ажиллагаандаа ERP системийг ашиглаж байна.	100
15	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын журмын хүрээнд тогтмол баяжуулах	Журмын дагуу баяжилт хийсэн эсэх /тийм үгүй/	Тийм	Ил тод байдлын журмын хүрээнд цахим сайтыг тогтмол баяжуулж иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.	100
Хэрэгжилт					100

